

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА  
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**БУЛГАН СУМЫН МИНЖИТ БУЛГАН ОНӨААТҮГ-ЫН 2020 ОНЫ ЖИЛИЙН  
ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

Аудитын код: ХОА-2021/7/СТА-ОНӨААН

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a></p> <p>Ховд хот 2021 он</p>	<p>Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 70433061 Цахим хаяг: BoldbaatarKh@audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас:70432545 Цахим хаяг: Tsetsegsurena@audit.gov.mn Гэрээт аудитор: Н.Батжаргал Утас: 70432545 цахим хаяг: Bataa0119@yahoo.com</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

### Товчилсон үгийн жагсаалт

<i>АДБОУС</i>	<i>Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт</i>
<i>АОУС</i>	<i>Аудитын Олон Улсын Стандарт</i>
<i>УСНББОУС</i>	<i>Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт</i>
<i>ТТЗ</i>	<i>Төсвийн төвлөрүүлэн захирагч</i>
<i>ТШЗ</i>	<i>Төсвийн шууд захирагч</i>
<i>ҮНӨААТҮГ</i>	<i>Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар</i>
<i>ОНХС</i>	<i>Орон нутгийн хөгжлийн сан</i>
<i>НББ</i>	<i>Нягтлан бодох бүртгэл</i>

## Агуулга

1.ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН САНАЛ, ДҮГНЭЛТ .....	3	
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН .....	4	
2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН	төгрөгөөр .....	4
2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН	төгрөгөөр .....	5
2.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН	төгрөгөөр .....	6
2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН.....		7
3.АУДИТЫН ТАЙЛАН.....		8
3.1. Ерөнхий зүйл.....		8
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....		8
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт .....		8
3.4. Материаллаг байдал .....		9
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....		9
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт .....		9
3.7. Шилэн дансны мэдээлэл.....		10
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....		10
3.9. Аудитын илрүүлэлт.....		10
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд .....		11
4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ.....		11
5. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ .....		12

## 1.ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН САНАЛ ДҮГНЭЛТ



ХОВД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
В4000 Цамбагараа баг, Жаргалант сум, Ховд  
Утас: 975-70433091, Факс: 975-70433091  
E-mail: khovd@audit.gov.mn

БУЛГАН СУМЫН МИНЖИТ БУЛГАН  
ОНӨААТҮГ-ЫН ДАРГА  
Б.МӨНХТӨР ТАНАА

2021.01.28 № 2/06  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Булган сумын Минжит булган ОНӨААТҮГ-ын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Булган сумын Минжит булган ОНӨААТҮГ 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Булган сумын Минжит булган ОНӨААТҮГ-ын 2020 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтөлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

### Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *Х.Болдбаатар* Х.БОЛДБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>13,205,724.12</u></b>	<b><u>4,444,236.00</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	13,205,724.12	4,444,236.00
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	13,205,724.12	4,444,236.00
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	13,205,724.12	4,444,236.00
31213	Арилжааны банк дахь харилцах	13,205,724.12	4,444,236.00
<b>321</b>	<b>Үнэт цаас</b>	-	-
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	-	-
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	-	-
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	-	-
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>3732</b>	<b>Гадаад зээлээс дамжуулан зээлдүүлсэн зээлийн авлага</b>	-	-
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>13,205,724.12</u></b>	<b><u>4,444,236.00</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>10,000,000.00</u></b>	<b>-</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	10,000,000.00	-
<b>413</b>	<b>Өглөг</b>	10,000,000.00	-
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	10,000,000.00	-
<b>4212</b>	<b>Гадаад валют</b>	-	-
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	3,205,724.12	4,444,236.00
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	3,205,724.12	4,444,236.00
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан		-
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	3,205,724.12	4,444,236.00
51210	Өмнөх үеийн үр дүн	21,225,930.00	3,205,724.12
51220	Тайлант үеийн үр дүн	(18,020,205.88)	1,238,511.88
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>13,205,724.12</u></b>	<b><u>4,444,236.00</u></b>

## 2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	59,965,874.60	73,221,164.80
11	ТАТВАРЫН ОРЛОГО	26,455,989.60	27,511,864.80
110	Орлогын албан татвар	26,455,989.60	27,511,864.80
110002	Үйл ажиллагааны орлого	26,455,989.60	27,511,864.80
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	33,509,885.00	27,511,864.80
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	27,511,864.80
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих		45,709,300.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	33,509,885.00	
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	33,509,885.00	45,709,300.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	77,986,080.48	71,982,652.92
21	УРСГАЛ ЗАРДАЛ	77,986,080.48	71,982,652.92
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	77,986,080.48	71,982,652.92
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	10,682,790.00	28,372,807.80
210101	Үндсэн цалин	10,682,790.00	28,372,807.80
210105	Гэрээт ажлын хөлс		
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,566,218.00	5,365,972.00
210201	Тэтгэврийн даатгал	4,566,218.00	5,365,972.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	6,969,553.32
210301	Гэрэл, цахилгаан	-	6,969,553.32
210302	Түлш, халаалт	-	
210303	Цэвэр, бохир ус		
2104	Хангамж, бараа материалын зардал	20,144,010.00	19,548,490.00
210401	Бичиг хэрэг	566,500.00	633,000.00
210402	Тээвэр, шатахуун	19,577,510.00	12,916,190.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		368,100.00
210408	Бараа материал акталсны зардал		
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/		-

210410	Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/		5,631,200.00
2105	Нормативт зардал	-	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,382,991.00	-
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,382,991.00	
2107	Томилолт, зочны зардал	-	250,000.00
210701	Гадаад албан томилолт		
210702	Дотоод албан томилолт		250,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	37,210,071.48	11,475,829.80
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	37,210,071.48	11,475,829.80
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(18,020,205.88)	1,238,511.88
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(18,020,205.88)	1,238,511.88

### 2.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>69,965,875.20</b>	<b>73,221,164.80</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	26,455,989.60	<b>27,511,864.80</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	26,455,989.60	27,511,864.80
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	43,509,885.60	45,709,300.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	43,509,885.60	45,709,300.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>77,920,150.48</b>	<b>81,982,652.92</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>77,920,150.48</b>	<b>81,982,652.92</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>77,920,150.48</b>	<b>81,982,652.92</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	12,635,147.00	28,372,807.80
210106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/	12,635,147.00	28,372,652.80
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	1,832,094.58	5,365,972.00
210201	Тэтгэврийн даатгал	821,284.08	3,714,903.00
210202	Тэтгэмжийн даатгал	227,432.50	371,491.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	227,432.50	371,491.00
210204	Ажилгүйдлийн даатгал	50,540.50	825,534.00
210205	Эрүүл мэндийн даатгал	505,405.00	82,553.00

<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>		6,969,553.32
210301	Гэрэл, цахилгаан	-	6,969,553.32
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	20,144,010.00	19,548,490.00
210401	Бичиг хэрэг	566,500.00	633,000.00
210402	Тээвэр, шатахуун	19,577,510.00	12,916,190.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		368,100.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал		5,631,200.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	5,382,991.00	-
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,382,991.00	-
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	0.00	250000.00
210702	Дотоод албан томилолт		250,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	37,925,907.90	21,475,829.80
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	37,925,907.90	21,475,829.80
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>(7,954,275.28)</b>	<b>(8,761,488.12)</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>-7954275.88</b>	<b>(8,761,488.12)</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	21160000.00	13,205,724.12
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	13205724.12	4,444,236.00

## 2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01				21,225,930.00		21,225,930.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>21,225,930.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
C07	Тайлант үеийн үр дүн			-18,020,205.88		-
C08	<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>3,205,724.12</b>	<b>0.00</b>	<b>3,205,724.12</b>
D01	<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>3,205,724.12</b>	<b>0.00</b>	<b>3,205,724.12</b>
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>		<b>0.00</b>	<b>0.00</b>
D08	Тайлант үеийн үр дүн			1,238,511.88		1,238,511.88
D09	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>4,444,236.00</b>	<b>0.00</b>	<b>4,444,236.00</b>

### 3.АУДИТЫН ТАЙЛАН

#### 3.1. Ерөнхий зүйл

Булган сумын Минжит булган ОНӨААТҮГ газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг дарга Б.Мөнхтөр танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагчийн дотоод хяналт болон нягтлан бодох бүртгэл хөтлөлтийн талаар зөвлөмж өгч менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-наас 2021 оны 01 дугаар сарын 27-ны хооронд Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын гэрээт аудитор Н.Батжаргал хариуцаж хэрэгжүүлэв.

#### 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

**Үйл ажиллагааны чиглэл:** Минжит булган хот тохижилт ОНӨААТҮГ нь Булган сумын ард иргэд, айл өрх, ААН,албан байгууллагуудын сумын нийтийн эзэмшлийн зам талбай, хашаа, хайс, ногоон байгууламж, гэрэлтүүлгийн ашиглалт, хамгаалалтанд хяналт тавих, засвар үйлчилгээ хийх, гүний худаг, нийтийн халуун усны үйлчилгээг орон нутгийн иргэдэд үзүүлэх гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Минжит булган хот тохижилт ОНӨААТҮГ-ын үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Минжит булган хот тохижилт ОНӨААТҮГ-ын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон СТОУС, түүнд нийцүүлэн гаргасан Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор “Төрийн албан хаагчийн цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”*
- *Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 183 тоот “бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай”*
- *Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 10 тоот “төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай”*

#### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Булган сумын Минжит булган ОНӨААТҮГ нь санхүүгийн тайлангаа Төсвийн тухай хууль болон СТОУС, түүнд нийцүүлэн баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй, нягтлан бодох бүртгэлийн хууль, холбогдох стандарт, заавар журмын дагуу нягтлан бодох бүртгэлийг хөтөлж хэвшээгүй байна.

### 3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, эрсдэлийн түвшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт орлогын 71970.0 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 7197.0 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон.

Харин гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт орлогын 73221.0 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 732.2 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцлоо.

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Булган сумын Минжит булган ОНӨААТҮГ-ын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 8761.5 мянган төгрөгөөр буюу 66 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, өр төлбөрийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Тайлангийн үзүүлэлтүүд	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Мөнгөн хөрөнгө	13205.7	4444.2	-8761.5
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	13205.7	4444.2	-8761.5
<b>Богино хугацаат өр төлбөр</b>	<b>10000.0</b>		-10000.0
Цэвэр хөрөнгө, өмч	3205.7	4444.2	1238.5
<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	13205.7	4444.2	-8761.5

Оны эхэнд мөнгөн хөрөнгө 13205.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан бөгөөд тайлант үед 72295.1 мянган төгрөгийн мөнгөн орлого төвлөрч, 80119.2 мянган төгрөгийн зөрлөг гарч үлдэгдэл 4444.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.

Өр төлбөр оны эхэнд 10000.0 мянган төгрөг байсан. Энэ нь сумын тамгын газраас гүүр засварлах мөнгийг тухайн газрын дансанд төвлөрүүлсэн байсан бөгөөд тендер зарлан гүйцэтгэгчийг шалгаруулж мөнгийг шилжүүлэн өгсөн байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй байна.

### 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### Төсвийн төлөвлөлт:

Тус байгууллагын 2020 оны төсвийг Сумын ИТХ-ын 2019 оны 12 дугаар сарын 18 ний өдрийн 09 тоот тогтоолоор орлогыг 80910.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 80910.0 мянган төгрөгөөр тооцож баталсан байна.

### Төсвийн гүйцэтгэл:

Гүйцэтгэлээр нийт 73221.1 мянган төгрөгийн орлого төвлөрсөн байна. Үүний 18063.9 мянган төгрөг нь хог хаягдлын хураамжаас, 7080.0 мянган төгрөг тариа хураалтаас, 4540.2 мянган төгрөг нь бохирын машин, засварын ажил квошоор ажил гүйцэтгэснээс, 24287.0 мянган төгрөг нь ОНХС-аас татаас хэлбэрээр, 14250.0 мянган төгрөг нь гэрэлтүүлгийн төлбөрөөр, 5000.0 мянган төгрөг нь засварын ажлын санхүүжилтээр ЗДТГ-аас орсон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 71982.6 мянган төгрөг байна. Үүнээс цалинд 28372.8 мянган төгрөг, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалд 5365.9 мянган төгрөг, гэрэл цахилгаанд 6969.5 мянган төгрөг, 19180.3 мянган төгрөгийн хангамж бараа материалын зардалд, бусад зардлуудад 11475.8 мянган төгрөг зарцуулсан байна.

### 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хянахад хугацаандаа оруулсан 138, хугацаа хоцорч оруулсан 6 зүйл байна. Хугацаа хоцорсон зүйлсэд байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэлтэй холбоотой 2, Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэлтэй холбоотой 2, Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлттэй холбоотой 2 мэдээлэл байна.

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 2000.0 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгөгдсөний 1 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна. Энэ нь НББ-ийн бодлогын баримт бичгийг боловсруулан мөрдөж ажиллах гэсэн зөвлөмж байсан бөгөөд тухайн байгууллага нь үйл ажиллагаа жигдрээгүй, тамгын газарт бүртгэлтэй байгаа үндсэн хөрөнгийг ашиглан үйлчилгээ үзүүлж ажилладаг, бүртгэлд олон төрлийн хөрөнгө байдаггүй болон төсөв санхүүгийн хувьд төсвөөс хараат байгууллагын хэлбэр нь тодорхой бус байдалтайгаас зэргээс үүдэн зөвлөмжийг хэрэгжүүлэх боломжгүй байсан гэсэн тайлбарыг өглөө.

Хүснэгт 2. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт /мян.төг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	2000.0	1	2000.0		0	
Зөвлөмж	1	0	0	0	1	0	0
<b>Нийт дүн</b>	<b>2</b>	<b>2000.0</b>	<b>1</b>	<b>2000.0</b>	<b>1</b>	<b>0</b>	<b>50</b>

### 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 10413.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 10413.8 мянган төгрөгийн залруулга хийгдэж, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

**Залруулсан алдаа:** Аудитаар 10413.8 мянган төгрөгийн зардлыг илүү бүртгэсэн 1 алдааг залрууллаа.

**Аудитын зөвлөмж:** Аудитаар илэрсэн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

### **3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД**

Дараагийн аудитаар орлого төвлөрүүлэлтийн асуудлыг авч үзэх хэрэгтэй гэж үзлээ.

## **4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ**

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

### **1. Дотоод хяналт**

1.1. **Илрүүлэлт.** Байгууллага бие даан өөрийгөө санхүүжүүлэх эх үүсвэр дутагдалтай байдлаас хамааран удирдлага буюу дарга нь орон тооны бус, нягтлан бодогч нярвын ажлыг давхар хийж байгаа нь НББ-ийн тухай хуулийн 19.1. “Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно” 18.1. “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” гэсэн заалтуудыг зөрчиж байна.

**Эрсдэл:** Дотоод хяналт алдагдах, төрийн өмч түүнээс бий болсон өгөөжийг зүй бус зарцуулах

1.2. **Өгсөн зөвлөмж:** байгууллагын дотоод хяналтыг сайжруулан, үр дүнтэй дотоод хяналтыг бий болгох.

1.3. **Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Хүлээн зөвшөөрсөн

### **2. НББ хөтлөлт**

2.1. **Илрүүлэлт:** Нягтлан бодох бүртгэлийн заавал хөтлөх журнал, ерөнхий данс, дэлгэрэнгүй бүртгэлийг хөтлөөгүй, дансны нэгдсэн төлөвлөгөөгүйгээр санхүүгийн тайланг бэлтгэн гаргасан байна.

**Эрсдэл:** Энэ нь байгууллагын санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд буруу илэрхийлэгдэх, хөрөнгийн зүй бус зарцуулалт ашиглалт бий болох

2.2. **Өгсөн зөвлөмж:** НББ-ийн тухай хуулийн 14.3. “Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг дараах дарааллаар гүйцэтгэнэ” гэснийг мөрдөн ажиллах

2.3. **Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Хүлээн зөвшөөрсөн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 5 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ

Огноо:	Аудитын нэр:	Булган сумын Минжит булган ОНӨААТҮГ-ын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2021			ХОА-2021/7/СТА-ОНӨААН-
Шалгагдсан байгууллагын нэр:	Булган сумын Минжит булган ОНӨААТҮГ	Мянган төгрөгөөр	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Байгууллага бие даан өөрийгөө санхүүжүүлэх эх үүсвэр дутагдалтай байдлаас хамааран удирдлага буюу дарга нь орон тооны бус, нягтлан бодогч нярвын ажлыг давхар хийж байгаа нь дотоод хяналтыг сулруулж байна		Зөвлөмж өгөх	Дарга, нягтлан бодогч	Б.Мөнхтөр Ш.Аззаяа
2	Нягтлан бодох бүртгэлийн заавал хөтлөх журнал, ерөнхий данс, дэлгэрэнгүй бүртгэлийг хөтлөөгүй, дансны нэгдсэн төлөвлөгөөгүйгээр санхүүгийн тайланг гаргасан байна		Зөвлөмж өгөх		
<b>ДҮН</b>					

### ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР